СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023 | IX

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

2023
9 сар

Баруун-Урт сум

Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон үгийн тайлал.

- Сумдын нэр:

АС Асгат	ТШ Түвшинширээ
БД Баяндэлгэр	ТЦ Түмэнцогт
ДА Дарьганга	УБ Уулбаян
МХ Мөнххаан	ХА Халзан
НА Наран	ЭЦ Эрдэнэцагаан
ОН Онгон	БУ Баруун-Урт
СҮ Сүхбаатар	

- 'Төл' гэсэн нь төлөвлөгөө, 'Гүйц' гэсэн нь гүйцэтгэл юм.

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв.

- Сар: I, II, III, IV, V, VI … г.м
- Улирал: I-III, IV-VI, VII-IX, X-XII
- Өссөн дүн: I-VI, I-XI ... г.м (Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдсэн дүнг харуулав)

III. Дараах тэмдэглэлийг ашиглав.

...	Мэдээлэл байхгүй	-	Гүйцэтгэл байхгүй
0.0	Маш бага тоо	*	Урьдчилсан гүйцэтгэл
¹	Дахин		

a^x х нь өмнөх оны мөн үетэй харьцуулсан цэвэр өсөлт, бууралтын хувь

▲▼ эерэг хандлага, эерэг өөрчлөлт ▲▼ сөрөг хандлага, сөрөг өөрчлөлт

IV. Хэмжих нэгжийн тэмдэглэгээ.

- мянга =1000
- сая $=10^6$
- тэрбум $=10^9$
- см сантиметр
- дм дециметр
- м метр
- км километр
- мян. мянга
- % хувь
- кВт.ц киловатт цаг
- ккал килокалори
- $м^2$ метр квадрат
- $км^2$ километр квадрат
- $м^3$ метр куб
- мл миллилитр
- л литр
- г грамм
- кг килограмм
- цн центнер
- т тонн
- ш ширхэг

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

V. Орон дэвшүүлэхээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас их, бага зэрэг зөрүүтэй байж болно.

ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл 2

Үндсэн үзүүлэлтүүд 5

I Хүн ам 6-7

II Хөдөлмөр 8-9

III Нийгмийн даатгал, халамж 10-12

VI Боловсрол 13

V Эрүүл мэнд 14-16

VI Соёл, урлаг 17

VII Гэмт хэрэг 18-19

VIII Мөнгө, банк 20-21

IX Арилжааны даатгал 22-23

X Орон нутгийн төсөв 24

XI Төсөл, хөтөлбөр 25

XII Үнэ 25-30

XIII Хөдөө аж ахуй 31-35

XIV Аж үйлдвэр 36-39

XV Тээвэр 40-41

Хавсралт хүснэгтийн жагсаалт 42-43

Хавсралт хүснэгтүүд 44-75

БҮЛЭГ	ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭСЭН:
Үндсэн үзүүлэлтүүд /Хүснэгт/	Э.Анхцэцэг
I Хүн ам	С.Мөнхбаяр
II Хөдөлмөр	Э.Анхцэцэг
III.а Нийгмийн даатгал	Б.Сумъяа
III.б Нийгмийн халамж	С.Мөнхбаяр
IV Боловсрол	Б.Сумъяа
V Эрүүл мэнд	С.Мөнхбаяр
VI Соёл, урлаг	С.Мөнхбаяр
VII Гэмт хэрэг	Б.Сумъяа
VIII Мөнгө, Банк	Б.Сумъяа
IX Арилжааны даатгал	С.Мөнхбаяр
X Орон нутгийн төсөв	Ц.Азжаргал
XI Төсөл, хөтөлбөр	Ц.Азжаргал
XII.а Хэрэглээний үнэ	Б.Сумъяа
XII.б Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ	С.Мөнхбаяр
XIII Хөдөө аж ахуй	С.Мөнхбаяр
XIV Аж үйлдвэр	Э.Анхцэцэг
XV Тээвэр	С.Мөнхбаяр

ХЭВЛЭЛИЙН ЭХ БЭЛТГЭСЭН: Э.Анхцэцэг

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 9 дүгээр сарын байдлаар

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX
Төрсөн хүүхэд	хүн	1 066 8.1	809 -24.1	936 15.7
Нялхасын эндэгдэл	хүн	5 -55.5	7 40	4 -42.9
Бүртгэлтэй ажилгүй иргэд	хүн	496 -2.4	352 -29.0	71 -78.8
Халдварт өвчнөөр өвчдөгчид	хүн	7 022 17.8**	4 091 -41.7	784 -80.8
Бүртгэгдсэн гэмт хэрэг	тоо	256 -14.7	430 68.0	373 -13.2
Хэрэгт холбогсод	хүн	175 -26.2	304 73.7	216 -28.9
Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт, оны эцэстэй харьцуулснаар, хувиар	хувь	107.5 .6.8	108.4 0.9	109.1 0.7
Иргэдийн хадгаламж	тэрбум төгрөг	144.4 41.8	131.7 -8.8	137.5 4.4
Зээлийн өрийн үлдэгдэл	тэрбум төгрөг	171.8 25.9	197.6 31.3	236.2 11.3
Орон нутгийн төсвийн орлого	тэрбум төгрөг	54.3 7.8	37.2 -31.5	55.7 49.6
Орон нутгийн төсвийн зарлага	тэрбум төгрөг	49.9 -1.8	34.8 -30.2	43.4 24.8
Төллөсөн хээлтэгч	мян.тол	1 425.1 0.4	1 558.0 9.3	1 548.0 -0.6
Ингэ	мян.тол	1.3 -14.4	1.4 9.6	1.3 -8.5
Гүү	мян.тол	84.3 5.5	91.7 8.8	91.4 -0.3
Үнээ	мян.тол	87.2 6.3	96.3 10.5	92.7 -3.8
Эм хонь	мян.тол	781.1 -0.6	868.4 11.2	874.6 0.7
Эм ямаа	мян.тол	471.3 -1.2	500.2 6.1	488.0 -2.4
Бойжуулсан төл	мян.тол	1 413.1 0.3	1 547.8 9.5	1 119.3 -27.7
Ботго	мян.тол	1.3 -10.9	1.4 10.0	1.2 -12.1
Унага	мян.тол	83.7 5.9	91.2 8.9	74.1 -19.4
Тугал	мян.тол	86.5 6.5	95.7 10.6	77.2 -19.4
Хурга	мян.тол	776.6 -0.1	864.1 11.3	631.7 -26.9
Ишиг	мян.тол	465.0 -1.0	495.5 6.6	335.1 -32.4
Том малын зүй бусын хорогдол	мян.тол	42.9 12.5	13.4 -68.8	566.4 42.4**
Тэмээ	мян.тол	0.04 85.0	0.03 -10.8	0.1 2.8**
Адуу	мян.тол	2.0 44.8	1.5 -25.9	26.7 18.1**
Үхэр	мян.тол	4.4 66.2	1.5 -65.3	29.7 19.4**
Хонь	мян.тол	16.9 -8.5	4.9 -71.1	266.2 54.3**
Ямаа	мян.тол	19.5 25.3	5.4 -72.2	243.7 44.9**
Үүнээс: Өвчнөөр хорогдсон мал	тол	14 40.0	210 42.0**	83 -60.5
Үхэр	тол	14 40.0	89 6 4**	-
Хонь	тол	-	56	83 48.2
Ямаа	тол	-	65	-
Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	109.8 28.4	120.2 9.5	160.1 33.3
Борлуулсан бүтээгдэхүүн	тэрбум төгрөг	175.1 11.9	270.6 54.5	335.3 23.9

Тайлбар: ** дахин

ХҮН АМ, жил бүрийн эхний 9 сард
Амаржсан эх
932
14.9%
Төрсөн хүүхэд
936
15.7%
1 000 хүнд ногдох
Ердийн цэвэр өсөлт
12
9
11
2021 I-IX
2022 I-IX
2023 I-IX
Төрөлт
16
12
14
2021 I-IX
2022 I-IX
2023 I-IX
Нас баралт
4
4
3
2021 I-IX
2022 I-IX
2023 I-IX

Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 15.7 хувиар өсчээ.

Эрүүл мэндийн газраас гаргадаг мэдээлээр 2023 оны эхний 9 сард 932 эх амаржиж, 936 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 121(14.9%)-аар, төрсөн хүүхэд 127(15.7%)-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 1. ТӨРӨЛТ, жил бүрийн эхний 9 сард



1000 хүнд ногдох төрөлт 14.2 болж өмнөх оноос 1.9 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 2. НАС БАРАЛТ, жил бүрийн эхний 9 сард



2023 оны эхний 9 сард нас баралт 227 болж, өмнөх оноос 9(3.8%)-аар буурчээ. 1000 хүнд ногдох төрөлт 14, нас баралт 3, ердийн цэвэр өсөлт 11 байна. 1000 хүнд ногдох нас баралт өмнөх оноос 0.2 нэгж хувиар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хүн амын ердийн цэвэр өсөлт нь төрөлт, нас баралтын зөрүүгээр тодорхойлно.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газар

ХӨДӨЛМӨР, бүртгэлтэй ажил хайгч иргэд
2023 оны 9 дүгээр сард
Нийт дүн
71
Эмэгтэй
41
Эрэгтэй
30
БҮРТГЭЛТЭЙ АЖИЛ ХАЙГЧ ИРГЭД, насны бүлгээр, тоогоор
15-24
14
25-34
25
35-44
21
45-54
7
55-59
2
60+
2

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо өмнөх сараас 65.6 хувиар буурлаа.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 2023 оны 9 сарын эцэст 71 болсны 41 (57.7%) нь эмэгтэйчүүд байна. Эдгээр бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 281 (79.8%) хүнээр, 2022 оны 12 сарын эцсээс 292 (80.4%) хүнээр тус тус буурсан байна.

Эхний 9 сарын байдлаар Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт 1204 ажилгүй иргэн шинээр бүртгүүлсний 380 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

ЗУРАГ 3. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙГУУЛЛАГАД ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН БОЛОН АЖИЛД ЗУУЧЛАГДАН ОРСОН ИРГЭД, жил бүрийн эхний 9 сарын байдлаар



Ажилгүй иргэдийн 60 (84.5%) нь 15-44 насныхан эзэлж байгаа юм.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 18 (25.4%) нь бакалавр, 4 (5.6%) нь мэргэжлийн анхан шат, 21 (29.6%) нь бүрэн дунд, суурь, 7 (10.0%) нь бага боловсролтой хүмүүс байна.

ЗУРАГ 4. БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, боловсролын түвшингээр, 9 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт:

Хөдөлмөр: Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

Эх үүсвэр: Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын бүртгэлтэй ажилгүй иргэдийн сарын мэдээ

НИЙГМИЙН ДААТГАЛ, 2023 оны эхний 9 сард

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САН, сая төгрөг



* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД

ТЭТГЭВЭРАВАГЧИД 9713

- Өндөр насны тэтгэвэр 7 505
- Тахир дутуугийн тэтгэвэр 1 422
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 395
- Цэргийн тэтгэвэр 369
- Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр 22

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ өмнөх оноос 3.5 (1.7%) тэрбум төгрөгөөр өслөө.

Аймгийн хэмжээнд сайн дурын даатгуулагчид 1.1 тэрбум төгрөгийн шимтгэл төлж, өмнөх онтой харьцуулахад 0.2 (25.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

2023 оны 9 сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас нийт 9.7 мянган иргэнд 48.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосноос, 7.5 мянган өндөр настанд 37.5 тэрбум төгрөг, 1.4 мянган тахир дутуу иргэнд 5.1 тэрбум төгрөг, 0.4 мянган тэжээгчээ алдсан иргэнд 2.8 тэрбум төгрөг, 0.4 мянган иргэнд цэргийн тэтгэвэрт 3.2 тэрбум төгрөг, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчтөний даатгалаас 0.02 мянган иргэнд 0.1 тэрбум төгрөгийг тус тус бүрэн олгосон байна. Нийт тэтгэвэр авагчдын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 193 (2.0%) хүнээр өсжээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр 2023 оны эхний 9 сард нийгмийн халамжийн тэтгэвэрт 1457 хүн хамрагдсан нь өмнөх оноос 117(8.7%) хүнээр, олгосон тэтгэврийн хэмжээ 3.7 тэрбум төгрөг болж 377.3 (11.5%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэмжид 2023 оны эхний 9 сарын байдлаар 2422 хүн хамрагдсаны 50.5 хувь нь асаргааны тэтгэмжид, 49.5 хувь нь онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн тэтгэмжид 2.2 тэрбум төгрөг олгосон нь өмнөх оноос 0.7 (41.6%) тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

ХҮСНЭГТ 1. НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАГЧИД, төрлөөр, эхний 9 сар

Үзүүлэлт	2021 I-IX		2022 I-IX		2023 I-IX	
	Хүний тоо	сая төгрөг	Хүний тоо	сая төгрөг	Хүний тоо	сая төгрөг
Бүгд	**26 396**	**8 435.2**	**25 631**	**8 404.3**	**25 040**	**9 573.6**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	9 220	5 295.8	6 824	5 140.7	5 000	6 036.3
Нийгмийн халамжийн тэтгэвэр	1 256	3 226.1	1 340	3 282.7	1 457	3 660.0
Нийгмийн халамжийн тэтгэмж	2 179	1 496.0	2 213	1 570.6	2 422	2 224.1
Нийгмийн халамжийн үйлчилгээ	46	30.8	172	60.3	159	69. 8
Нийгмийн хөгжлийн үйлчилгээ	5 739	542.9	3 099	227.1	962	82.4
Алдар эхийн одонгийн мөнгөн урамшуулал	5 473	722.4	5 659	735.7	5 795	747.7
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	4 403	117.0	4 669	224.6	5 225	407.6
Алдар цолтон амхад настанд үзүүлсэн нэмэгдэл, хөнгөлөлт	-	-	5	1.4	7	0.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	330	65.9	326	66.1	389	104.3
Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмж	4 220	1 796.2	5 312	1 787.3	5 375	1 777.0
Насны хишиг	2 750	437.9	2 836	448.5	3 249	500.0

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 962 хүн хамрагдсан нь өмнөх оноос 2137 (69.0%) хүнээр буурсан нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдах өрхийг тодорхойлох журмаа өөрчилсөнтэй холбоотой.

Ойлголт, тодорхойлолт

Нийгмийн даатгал: Иргэн, төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэн, даатгуулагч иргэн өндөр наслах, хөгжлийн бэрхшээлтэй буюу хөдөлмөрийн чадваргүй болох, өвчлөх, ажилгүй болох үед өөрт нь, тэрчлэн нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр олгох зориулалттай нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Нийгмийн даатгалын сан: Ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах, нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг хэлнэ.

Даатгуулагч: Хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг хэлнэ.

Тэтгэвэр: Даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөдөлмөрийн чадвараа алдсан бол хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний асрамжид байсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд нийгмийн даатгалын сангаас сар бүр олгох мөнгөн олговор юм.

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын орлого, зарлагын улирлын мэдээ, Хөдөлмөр халамж үйлчигээний газрын халамжийн сарын мэдээ

2023-2024 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын тоо өмнөх оноос 424-өөр өслөө.

Ерөнхий боловсролын сургуульд 2023-2024 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 14.2 мянган суралцагчид байгаагийн 7.1 (50.1%) мянга нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс суралцагчдын тоо 424 (3.0%) хүүхдээр өсчээ.

Нийт суралцагчдын 7.2 (50%) мянга нь 1-5-р ангид, 5.0 (35.2%) мянга нь 6-9-р ангид, 1.8 (12.7%) мянга нь 10-12-р ангид суралцаж байна.

Энэ хичээлийн жилд 1-р ангид 1.4 мянган суралцагчид элсэн орсны 687 (48.1%) эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 18 (1.2%) суралцагчаар буурсан байна. Мөн 12-р ангид 594 суралцагчид байгаагийн 327 (55.0%) нь эмэгтэй суралцагчид байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 52 (8.7%) суралцагчаар өссөн байна.

Энэ хичээлийн жилд 472 бүлэг хичээллэж байгаа бөгөөд нэг ангид 30.1 суралцагч ногдож байна. 1 багшид ногдох суралцагчийн тоо 21 байгаа нь өмнөх оны мөн үетэй ижил түвшинд байна.

Нийт ажиллагсдын 682 (59.6%) үндсэн багш байна. Үүний 557 (81.7%) нь эмэгтэй багш нар байна. Өмнөх оны мөн үеэс багш нарын тоо 38 (5.6%) багшаар өссөн байна.

Дотуур байранд 1090 сурагч амьдарч байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 120 (11.0%) сурагчаар өсчээ.

ЗУРАГ 5. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧДЫН ТОО



Сургуулийн өмнөх боловсрол 2023-2024 оны хичээлийн жилд 163 бүлэгт 5.6 мянган хүүхэд хүмүүжиж байгаагийн 2.7 (48.2%) мянга нь эмэгтэй хүүхэд байна. Өмнөх оны мөн үеэс 1.0 мянган (17.8%) хүүхдээр өсчээ.

2023-2024 оны хичээлийн жилд СӨБ-д 639 ажиллагсад байгаагийн 188 (29.4%) нь үндсэн багш, 148 (23.2%) нь туслах багш байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үндсэн багшийн тоо 6 (3.2%)-р өссөн, туслах багш 1 (0.7%)-ээр буурчээ. Нийт үндсэн багш нарын 6 (3.2%), туслах багш нарын 4 (2.7%) нь эрэгтэй багш байна.

ЗУРАГ 6. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО



Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв: Сүхбаатар аймаг дахь мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд 2023-2024 оны хичээлийн жилд урьдчилсан байдлаар 13 мэргэжлээр 414 суралцагчид суралцаж байгаагийн 143 (34.5%) нь эмэгтэй суралцагчид байна. Өмнөх оны мөн үеэс нийт суралцагчдын тоо 27 (6.5%) суралцагчаар өссөн байна.

Нийт суралцагчдын 159 (38.4%) мэргэжлийн боловсрол эзэмшихээр 1 жилийн хугацаатай суралцаж байна.

Нийт суралцагчдын 70 (16.9%) барилгын засал чимэглэгч, 50 (12.7%) тогооч, 40 (9.7%) барилгын цахилгаанчин, 45 (10.9%) гагнуурчин, 23 (5.5%) гоо засалч, 30 (7.2%) төмөр замын барилгачин, 25 (6.0%) оёмол бүтээгдэхүүний оёдолчин, 30 (7.2%) төмөр замын барилгачин гэх мэт мэргэжлээр сурч байгаа нь олонх байна.

Эх үүсвэр: Боловсрол, шинжлэх ухааны газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн улирлын мэдээ.

ЭРҮҮЛ МЭНД, жил бүрийн эхний 9 сард

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчид



2022 I-IX 11 029

2023 I-IX 12 039

9.2% ↑

Нийт халдварт өвчнөөр өвчлөгчид

2022 I-IX 4 091

2023 I-IX 784

80.8% ↓

1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2022 I-IX 7

2023 I-IX 4

1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

2022 I-IX 4

2023 I-IX 5

Эхийн эндэгдэл гараагүй.

Эрүүл мэндийн газрын мэдээллээр 2023 оны эхний 9 сард 932 эх амаржсан нь өмнөх оноос 121 (14.9%)-аар өссөн байна. Нийт амаржсан эхийн 0.4 хувь нь гэртээ төрсөн байна.

Нийт амьд төрсөн хүүхдийн 890 (95.1%) нь төрсний дараа 1 цагийн дотор хөхөө амалсан, 31 (3.3%) нь 2500 граммаас бага жинтэй байна.

ХҮСНЭГТ 2. АМАРЖСАН ЭХ, ТӨРСӨН ХҮҮХЭД, эхний 9 сард

Үзүүлэлт	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX	2023 I-IX / 2022 I-IX
	тоо			хувь
Амаржсан эх	1 056	811	932	114.9
6, түүнээс дээш удаа хяналтад хамрагдсан	988	762	903	118.5
Гэрийн төрөлт	5	2	4	200.0
Амьд төрсөн хүүхэд	1 066	809	936	115.7
1 цагийн дотор хөхөө амалсан хүүхэд	994	735	890	121.1
төрөлхийн гажигтай төрсөн	8	5	6	120.0
2500 граммаас доош жинтэй төрсөн	32	26	31	119.2
Амьгүй төрсөн хүүхэд	4	4	4	100.0
Амьгүй төрөлтийн түвшин / 1000 нийт төрөлтөд ногдох/	3.8	4.9	4.3	87.8

2023 оны эхний 9 сард нас баралтын 227 тохиолдол бүртгэгдсэний 46 (20.3%) нь осол гэмтлийн улмаас, 57 (25.1%) нь хорт хавдарын өвчлөлийн улмаас нас барсан байна.

ХҮСНЭГТ 3. НАС БАРАЛТ, зарим үзүүлэлтээр, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX	2023 I-IX / 2022 I-IX
	тоо			хувь
Нас баралт	271	236	227	96.2
Эмнэлгийн нас баралт	53	49	40	81.6
Осол гэмтэлийн өвчлөл нас баралт	28	27	46	170.4
Хорт хавдрын өвчлөл нас баралт	89	71	57	80.3
0-1 насны эндэгдэл	5	7	4	57.1
1-5 хүртэлх насны эндэгдэл	1	4	5	125.0

Халдварт өвчнөөр өвлөгчид 2023 оны эхний 9 сард 784 болж, өмнөх оны мөн үеэс 3307(80.8%)-аар буурахад короновируст халдварын тохиолдол буурсан нь нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 4. ХАЛДВАРТ ӨВЧИН, өвчний төрлөөр, жил бүрийн эхний 9 сар

Халдварт өвчин	Хэмжих нэгж	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX	Өсөлт	
					тоо	хувь
Бүгд	**хүн**	**7 022**	**4 091**	**784**	**-3 307**	**19.2**
Вируст гепатит	хүн	4	3	3	0	100.0
Гар хөл амны өвчин	хүн	19	33	119	86	3.6 [1]
Бруцеллёз	хүн	-	2	-	-	-
Цусан суулга	хүн	13	16	25	9	156.3
Салхинцэцэг	хүн	3	13	202	189	15.5 [1]
Энтервируст халдвар	хүн	-	-	104	104	-
Гахайн хавдар	хүн	-	-	2	2	-
Улаан эсэргэнэ	хүн	-	-	13	13	-
Ёлом	хүн	-	-	1	1	-
Салмонеллт	хүн	-	-	19	19	-
Хачигт	хүн	-	-	4	4	-
Сүрьеэ	хүн	41	50	46	- 4	92.0
Тэмбүү	хүн	60	40	24	- 16	60.0
Трихомониаз	хүн	62	68	43	- 25	63.2
Заг	хүн	55	47	38	- 9	80.9
Ковид-19	хүн	6 765	3 819	141	-3 678	3.7

Өмнөх оны мөн үеэс салхин цэцгээр өвчлөгчид 189(15.5 дахин)-аар, гар хөл амны өвчин 86(3.6 дахин)-аар нэмэгдэж, шинээр энтервируст халдварын 104, улаан эсэргэнэ 13 тохиолдолоор нэмэгдэж, ковид 19 халдварын 141 тохиолдолд болж буурсан байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 9 сарын байдлаар 203.7 мянган хүнд үзлэг хийсэн нь урьд оны мөн үеэс 25.3 (14.2%) мянган хүнээр өсч, 12.0 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт 48.1 мянган хүн хамрагдсан нь урьд оны мөн үеэс 12.4(34.7%) мянган хүнээр өсжээ.

Түргэн тусламжийн дуудлага 12.3 мянган удаа гарсны 2.4 (19.5%) мянга нь алсын дуудлага байгаа нь урьд оны мөн үеэс 87 (3.5%) удаагийн дуудлагаар буурсан байна.

Ойлголт, тодорхойлолт:

1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

Эх үүсвэр: Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газрын сарын мэдээлэл

Соёл, урлаг

Хөгжимд жүжгийн театр: 2023 оны эхний 9 сард 7.3 мянган үзэгчдэд 24 удаа тоглолтоор үйлчилж, 26.3 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үеэс тоглолтын тоо 11 (84.6%)-аар, танхимын үзэгчдийн тоо 4.3 мянгаар буюу 2.4 дахин тус тус өссөн байна.

ЗУРАГ 5. НИЙТ ТОГЛОЛТЫН ТОО



ЗУРАГ 6. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



Музей: 2023 оны эхний 9 сард 5.9 мянган хүнд 2.4 мянган үзмэрээр үйлчилж, 0.8 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад үзмэрийн тоо 60 (4.6%)-оор нэмэгджээ.

ЗУРАГ 7. НИЙТ ҮЗМЭРИЙН ТОО



ЗУРАГ 8. НИЙТ ҮЗЭГЧДИЙН ТОО, мян.хүн



Номын сан: 2023 оны эхний 9 сард 49.9 мянган номоор 5.1 мянган уншигчдад үйлчилжээ. Өмнөх оны мөн үеэс номын тоо 0.6 (1.2%) мянгаар өсч, уншигчдын тоо 1.7 (25.0%) мянган хүнээр буурчээ.

ЗУРАГ 9. НИЙТ НОМЫН ТОО



ЗУРАГ 10. НИЙТ УНШИГЧДЫН ТОО, мян.хүн



Эх үүсвэр: Жаахан шарга хөгжим жүжгийн театр, Усгаатны зүйн музей, Нийтийн номын сангийн улирлын мэдээ.

ГЭМТ ХЭРЭГ, 2023 оны эхний 9 сард

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг

2022 I-IX	2023 I-IX	
430	373	-13.3% ↓

Хөнгөн хэрэг
312

Хүнд хэрэг
61

Илрүүлэлтийн хувь
44.5%

Гэмт хэргийн улмаас

Гэмтсэн хүн
140

Нас барсан хүн
10

Хохирол сая төг
762.0

Гэмт хэрэг үйлдэгсэд

Бүлгээр
10

Согтуугаар
112

Ял шийтгэгдэж байсан
41

Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оноос 57 (13.0%)-оор буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 10 хүн нас барж, 140 хүн гэмтэж бэртсэн бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 762.0 сая төгрөгийн хохирол учирсны 44.4 хувийг нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 216 хүн холбогдон сэжиглэгдсэний 112 (52%) хүн нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 491 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 65 (15%) хүнээр буурсан байна. Нийт эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс 237 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авахуулсан байна.

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлт 44.5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 7 нэгжээр өссөн байна.

Зураг 11. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН ТОО



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.

Эх үүсвэр: Цагдаагийн газрын бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээ

МӨНГӨ, ЗЭЭЛ, 2023 оны эхний 9 сард

Монгол улс

Нийт зээлдэгчийн тоо

2022 IX **34 463**

2023 IX **35 090**

Зээл 2023 IX

Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл **236.2** тэрбум төгрөг

1.7 тэрбум төгрөг Анхаарал хандуулах зээлийн өрийн үлдэгдэл

1.5 тэрбум төгрөг Чанаргүй зээл

Иргэдийн **137.5** тэрбум төгрөг

Хугацаатай **121.9** тэрбум төгрөг

Хугацаагүй **15.6** тэрбум төгрөг

Салбар нэгжийн тоо **35**

Ажилтнуудын тоо **209**

АТМ-ны тоо **32**

Карт эзэмшигчийн тоо **60 694**

Чанаргүй хугацаа хэтэрсэн зээл эхний 9 сарын байдлаар 1.5 тэрбум болж, нийт зээлийн өрийн үлдэгдлийн 0.6 хувийг эзэлж байна.

Монгол банкны мэдээллээр ХААН, Төрийн, Хас, Голомт банкнуудаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдэл 236.2 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 4.6 (2%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 38.6 (19.5%) тэрбум төгрөгөөр тус тус өсжээ.

Банкнуудад хадгалуулсан иргэдийн төгрөгийн хадгаламжийн хэмжээ 137.5 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх сараас 1.0 (0.7%) тэрбум, өмнөх оны мөн үеэс 5.8 (4.4%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Нийт хадгаламжийн 88.7 % нь хугацаатай, 11.3 % нь хугацаагүй хадгаламж байна.

Зураг 12. ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ, ХАДГАДАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, тэрбум төгрөг



Ойлголт, тодорхойлолт

Хэвийн зээл: Төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээл: Зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Чанаргүй зээл: Хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлийг хамруулна.

Эх үүсвэр: Сүхбаатар аймаг дахь Монголбанкны салбар, Банкны салбарын мэдээ

ДААТГАЛ, 2023 оны эхний 9 сар, мянган төгрөг

Сайн дурын даатгал	Хураамжийн орлого	Нөхөн төлбөр
Гэнэтийн осол, эмчилгээний	77 608.9	16 786.8
Хөрөнгийн	5 812.9	1 000.7
Авто тээврийн хэрэгслийн	189 445.3	66 337.3
Ачаа хүргэлт	24 213.7	-
Барилга угсралтын	-	-
Мал амьтдын	98 638.2	20 877.0
Агаарын хөлгийн	-	-
Зээлийн	183 740.1	11 560.2
Бусад	112 215.0	27 807.6
Албан журмын даатгал		
Жолоочийн хариуцлагын	319 014.7	75 623.6

Даатгалын нөхөн төлбөр өмнөх оноос 1.9 хувиар буурчээ.

Даатгалын хураамжийн орлого 2023 оны эхний 9 сард 1.0 тэрбум төгрөг хүрч өмнөх оноос 44.9 (4.2%) сая төгрөгөөр, даатгалын нөхөн төлбөрт 220.0 сая төгрөг олгосон нь өмнөх оноос 4.3 (1.9%) сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Даатгалын хураамжийн 68.5 хувийг сайн дурын даатгал, 31.5 хувийг албан журмын даатгал эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX	2023 I-IX / 2022 I-IX
	сая төгрөг			хувь
Хураамжийн орлого	413.6	1 056.6	1 011.7	95.8
Нөхөн төлбөр	49.4	224.3	220.0	184.8
Даатгуулагчдын тоо	13 806	37 297	28 081	75.3

Даатгалын хураамжийн нийт орлогын 319.0 (31.5%)-ийг сая төгрөгийг жолоочийн хариуцлагын даатгал, 189.4 (18.7)-ийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 183.7 (18.2%)-ийг зээлийн эрсдлийн даатгал, 98.6 (9.7%) малын индексжүүлсэн даатгал эзэлж байна.

Даатгалын нөхөн төлбөрийн 34.4 хувийг жолоочийн хариуцлагын даатгал, 30.2 хувийг тээврийн хэрэгслийн даатгал, 5.7 хувийг гэнэтийн осолын даатгал, 12.6 хувийг хурдан морь унаач хүүхдийн даатгал, 1.9 хувийг хөдөлмөрийн чадвараа түр алдсны даатгал, 9.5 хувийг малын интексжүүлсэн даатгал, 5.3 хувийг зээлийн эрсдэлийн даатгал тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Даатгалын нөхөн төлбөр: Гэрээний дагуу даатгалын тохиолдолд үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө юм.

Даатгалын үйл ажиллагаа: Даатгалын гэрээний дагуу даатгагч нь хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажилаагаа юм.

Даатгалын хураамж: Даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг ойлгоно.

Эх үүсвэр: Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны даатгалуудын улирлын мэдээлэл

Орон нутгийн төсвийн орлого өмнөх оноос 17.4 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт орлого 2023 оны эхний 9 сарын байдлаар 55.7 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 18.5 (49.6%) тэрбум төгрөгөөр, төсвийн зарлага санхүүжилт 43.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 8.6 (24.8%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 13. ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, тэрбум төг



Аймгийн нийт төсвийн 41.3 хувийг орон нутгийн төсвийн орлого, 12.5 хувийг улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг, 10.2 хувийг аймгаас авсан санхүүгийн дэмжлэг, 21.2 хувийг орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг, 11.5 хувийг урьд оны үлдэгдэл, 3.3 хувийг төсөвт байгууллагуудын өөрийн орлого тус тус эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт

Төрийн санхүү: Төсвийн орлого, зарлагын мэдээг Олон Улсын Валютын Сангийн стандарт ангиллаар 1995 оны 10-р сараас эхлэн жил бүр гаргаж байна. Аймгийн төсвийн орлого нь аймаг, сумын төсвийн орлогоос бүрдэнэ.

Аймгийн нэгдсэн төсөв нь татварын болон татварын бус орлого, улсаас авах санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого, орон нутгийн сангийн орлогын шилжүүлэг зэргээс бүрдэнэ.

Эх үүсвэр: Аймгийн төсвийн мэдээг Санхүү, төрийн сангийн хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

Аймгийн хэмжээнд малжуулах хөтөлбөрт 60 өрхийг 3290 толгой мал 300.0 сая төгрөгийн төслийг хэргжүүлжээ.

Аймгийн хэмжээнд олгосон төсөл хөтөлбөрийг хэрэгжилтийн байдлаар авч үзвэл: Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хэмжээнд 24 иргэнд 109.0 сая, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 34 иргэнд 286.0 сая, нийтийг хамарсан ажил зохион байгуулах хөтөлбөрийн хүрээнд 14 төслийн хүрээнлд 181 иргэнд 59.8 сая, мод тарих арга хэмжээнд 206 иргэнд 72.5 сая, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 29 иргэнд 12.5 сая, малжуулах төсөл хөтөлбөрийн хэмжээнд 60 өрхөд 300.0 сая төгрөгөөр 3290 толгой малыг тус тус олгоод байна.
ЖДҮ зээлийг 2023 оны 9-р сарын байдлаар аймгийн хэмжээнд ААНБ болон иргэдээс 22 төсөл ирсэнээс 8 төсөл шалгаран 963.9 сая төгрөгийн санхжүүлтийг авсан байна

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, ХХАҮГ-аас мэдээг авч нэгтгэсэн .

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр, хувиар

2023 оны 9 дүгээр сард



Тайлбар: Өмнөх оны мөн үетэй харьцуулснаар

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар өслөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард аймгийн хэмжээнд өмнөх оны мөн үеэс 9.1 хувь, өмнөх оны эцсээс 4.9 хувь, өмнөх сараас 0.2 хувиар өссөн байна.

ЗУРАГ 14. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), сараар, хувиар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 9.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 18.7 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 5.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 9.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 11.4 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 9.4 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ 9.0 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 13.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард өмнөх оны эцсээс 4.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 8.3 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 3.2 хувь, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ дүнгээрээ 9.8 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 11.1 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 0.2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.8 хувь, даатгал, санхүүгийн үйлчилгээний бүлгийн үнэ 12.8 хувь, бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.3 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2023 оны 9 дүгээр сард өмнөх сараас 0.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 0.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.1 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 6. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, хувиар, 2023 оны 9 дүгээр сард

Бараа үйлчилгээний бүлэг	2023 IX / 2022 IX	2023 IX / 2022 XII	2023 IX / 2023 VIII
Ерөнхий индекс	**109.1**	**104.9**	**100.2**
Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	118.7	108.3	100.3
Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодис	105.7	103.3	100.0
Хувцас, бөс бараа, гутал	109.6	105.6	100.5
Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлш	103.2	102.3	100.0
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	109.8	105.1	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	111.4	111.1	100.1
Тээвэр	99.6	98.3	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	100.2	100.2	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ	109.4	103.8	100.0
Боловсролын үйлчилгээ	100.0	100.0	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	109.0	107.1	100.0
Даатгал, санхүүгийн үйлчилгээ	112.8	112.8	100.0
Бусад бараа, үйлчилгээ	113.5	106.3	100.0

ЗУРАГ 15. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), сараар, хувиар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2023 оны 9 дүгээр сард өмнөх сараас 6.0 хувиар буурахад хонь, ямааны махны үнэ дунджаар 7.8 хувь, үхрийн махны үнэ 5.6 хувиар тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний үнийн индекс: Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд нас гүйцсэн малаас хязаалан гунан үхрийн үнэ хамгийн өндөр буюу 1.6 сая төгрөг байна.

Малын зах зээлийн дундаж үнийн 2023 оны 9 сарын мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад атны үнэ 1.2 сая төгрөг болж, 37.5 мянган төгрөгөөр буурсан бол, эр ямааны үнэ 141.8 мянган төгрөг болж, 8.7 мянган төгрөгөөр, хязаалан гунан үхрийн үнэ 1.6 сая төгрөг болж, 195.6 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.1 сая төгрөг болж, 126.2 мянган төгрөгөөр, эр хонины үнэ 218.3 мянган төгрөг болж, 14.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 16. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ, 9 сард, мянган төгрөг



Хязаалан гунан үхрийн үнэ 2023 оны 9 сард Түмэнцогт суманд хамгийн их буюу 2.5 сая төгрөг, Баяндэлгэр суманд хамгийн бага буюу 1.0 сая төгрөг байна.

ЗУРАГ 17. ХЯЗААЛАН ГУНАН ҮХРИЙН ДУНДАЖ ҮНЭ, 2023 оны 9 сард, мянган төгрөг

Хивэгний үнэ 2023 оны 9 дүгээр сард 25.0 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үетэй харьцуулхад хивэгний үнэ 7.0 мянган төгрөгөөр өссөн бол 1 боодол өвсний дундаж үнэ 8.2 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеэс 0.5 мянган төгрөгөөр өссөн байна. .

ЗУРАГ 18. ӨВС, ХИВЭГНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 9 сард



Ойлголт, тодорхойлолт:

Малын үнийн мэдээнд хүнсний болон ашиг шим, уналга, эдэлгээний зориулалтаар худалдан борлуулсан малын үнийг хамруулах бөгөөд харин шилмэл омгийн мах, сүүний чиглэлийн, хурдны морь зэрэг өндөр үнээр борлуулсан малын үнийг үнийн мэдээнд хамруулахгүй.

Тооцох аргачлал:

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.

МАЛ АЖ АХУЙ 2023 оны эхний 9 сард





Мал төллөлт аймгийн хэмжээнд 75.0 хувьтай байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 оны 9 сарын байдлаар оны эхний төллөх насны 2.1 сая хээлтэгч малын 1.5 сая (75.0%) нь төлжээ. Гүүний 71.4 хувь, үнээний 68.7 хувь, ингэний 41.6 хувь, эм хонины 77.4 хувь, эм ямааны 73.1 хувь нь төллөсөн байна.

ЗУРАГ 19. ХЭЭЛТЭГЧ МАЛ, ТӨЛИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, мянган толгой



Бойжуулсан төл 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 1.1 сая болж, бойжилтын хувь 72.2 хувь байна. Гарсан унаганы 81.1 хувь, тугалын 83.3 хувь, ботгоны 95.3 хувь, хурганы 72.1 хувь, ишигний 68.5 хувь нь бойжжээ.

Аймгийн хэмжээнд 431.8 мянган толгой төл мал хорогдсоноос унага 17.3 мянган толгой, тугал 15.5 мянган толгой, ботго 61 толгой, хурга 244.6 мянган толгой, ишиг 154.3 мянган толгой төл мал хорогдоод байна.

Оны эхний малын 12.2 хувь буюу 566.5 мянган толгой том мал 2023 оны эхний 9 сарын байдлаар зүй бусаар хорогдлоо.

ЗУРАГ 20. ХОРОГДСОН МАЛЫН ТОО, сумаар, мянган толгой



Хорогдолыг малын төрлөөр авч үзвэл 26.7 мянган толгой адуу, 29.7 мянган толгой үхэр, 97 толгой тэмээ, 266.2 мянган толгой хонь, 243.7 мянган толгой ямаа байна. Нийт хорогдсон малын 441.1 мянга (77.9%) нь аюулт үзэгдэлээр хорогдсон байна.

Ойлголт, тодорхойлолт:

Том малын зүй бус хорогдол: Гэнэтийн аюулаар буюу байгалийн аюулт үзэгдэл, өвчнөөр хорогдсон (халдвартай, халдваргүй), зэрлэг амьтанд идүүлсэн, бариулсан ба бусад шалтгаанаар хорогдсон төл малаас бусад малыг оруулна.

Оны эхний малд том малын зүй бус хорогдлын эзлэх хувь: Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Аймгийн хэмжээнд 335.6 тн төмс хурааж авсан байна.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 2023 оны 9 дүгээр сарын байдлаар ургац хураалтын явцын мэдээгээр төмс 335.6 тн, хүнсний ногоо 378.7 тн, үр тариа 1.8 мянган тн, тэжээлийн ургамал 2.1 мянган тн, техникийн ургамал 150 тн бэлтгээд байна.

ЗУРАГ 21. ХУРААСАН УРГАЦ, тн, жил бүрийн 9 сард



АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, 2023 оны эхний 9 сарын байдлаар

Уул уурхай, олборлолт, тэрбум төгрөг



Боловсруулах үйлдвэрлэл, тэрбум төгрөг

Цахилгаан хий, уур, агааржуулалт, тэрбум төгрөг

Ус хангамж, сувагжилтын систем, хог хаягдал, зайлуулахболон хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа, тэрбум төгрөг



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл өмнөх сараас 29.9 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 160.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 40.0 (33.3%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай олборлолт 27.1 (27.6%) тэрбум төгрөг, боловсруулах үйлдвэрлэл 11.0 (93.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 21. АЖ ҮЙЛДВЭРИЙН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, салбараар, сараар, сая төгрөг



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2023 оны эхний 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр125.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 27.1 (27.6%) тэрбум төгрөгөөр өсөхөд чулуун болон хүрэн нүүрс олборлолт 29.9 (37.1 дахин) тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт 6.3 (9.8%) тэрбум төгрөгөөр өссөн нь тус тус голлон нөлөөлсөн байна.

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт хүрэн нүүрс, хайлуур жоншны баяжмал, хайрга, шороо олборлолтын биет хэмжээ 20.3 хувиас 16.9 дахин өсчээ.

Боловсруулах аж үйлдвэрийн салбарт талх, хэвийн боов, бялуу, хэрчсэн гурил, малын мах, бууз банш, гутал, бетон зуурмаг зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 15.7 хувиас 3.2 дахин өссөн байна.

ХҮСНЭГТ 7. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Бүтээгдэхүүн	Хэмжих нэгж	2022 IX	2022 I-IX	2023* IX	2023* I-IX	2023* I-IX / 2022 I-IX
		тоо				хувь
Уул уурхай, олборлох аж үйлдвэр						
Хүрэн нүүрс	мян.т	4.2	36.1	83.1	611.9	16.9 [1]
Цайрын баяжмал	мян.т	5.9	56.9	5.0	51.3	90.1
Төмрийн хүдэр	мян.т	-	-	-	1.5	-
Төмрийн хүдрийн баяжмал	мян.т	-	40.9	-	-	-
Хайлуур жонш	мян.т	4.7	21.8	0.4	5.9	26.9
Хайлуур жоншны баяжмал	мян.т	3.4	13.5	0.6	16.2	120.3
Хайрга, шороо	мян.м3	-	-	0.3	0.4	-
Боловсруулах аж үйлдвэр						
Талх	т	39.8	383.1	65.2	443.4	115.7
Нарийн боов	т	8.6	70.1	8.4	54.6	77.8
Хэвийн боов	т	0.5	28.8	1.4	48.1	167.0
Бялуу	т	0.5	4.3	0.6	5.4	126.2
Хэрчсэн гурил	т	0.5	42.5	8.3	55.4	130.2
Малын мах	т	344.6	996.0	372.3	1428.4	143.4
Цэвэр ус	мян.л	88.4	792.9	60.1	515.1	65.0
Бууз, банш	т	1.72	12.4	5.6	26.5	2.1 [1]
Самнасан хонины ноос	т	-	-	301.4	482.3	-
Эсгий	мян.м	-	-	0.3	1.3	-
Монгол дээл, тэрлэг	ш	113	1 919	206	1 890	98.5
Бэлтгэлийн хувцас /өмд, цамц/	ш	135	149	40	85	57.0
Гутал	хос	18	116	10	372	3.2 [1]
Бетон зуурмаг	м3	536.0	5 774.0	1 362.4	6 734.2	116.6

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2023 оны эхний 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 335.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 64.7 (23.9%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлолтын салбарын борлуулалт 50.1 (20.1%) тэрбум төгрөгөөр, боловсруулах аж үйлдвэрийн 12.5 (2.1 дахин) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ХҮСНЭГТ 8. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сая.төг

Салбар	2022 I-IX	2023*		2023* I-IX / 2022 I-IX
		I-IX	Гадаад	
	тоо			хувь
Нийт дүн	**270 627.7**	**335 331.9**	**304 354.0**	**123.9**
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	249 378.1	299 426.3	295 782.7	120.1
Боловсруулах аж үйлдвэр	10 985.6	23 474.0	8 571.3	2.1 [1]
Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж	9 285.4	10 775.6	-	116.0
Усан хангамж, хог хаягдал зайлуулах, хүрээлэн буй орчныг дахин сэргээх үйл ажиллагаа	978.6	1 656.0	-	169.2

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн өмнөх оны мөн үеэс 64.7 (23.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд нүүрс олборлолтын салбарын борлуулалт 50.1 (20.1%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 22. УУЛ УУРХАЙ, ОЛБОРЛОХ АЖ ҮЙЛДВЭРИЙН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, салбараар, сараар, сая төгрөг

Гадаад зах зээлд 2023 оны эхний 9 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэлээр 304.4 тэрбум төгрөгийн борлуулалт хийсний 295.8 тэрбум нь уул уурхай, олборлох салбарын борлуулалт байна. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад борлуулалтын 15.4 хувийг нүүрс олборлолтын салбар, 74.3 хувийг металлын хүдэр олборлолтын салбар, 10.3 хувийг бусад ашигт малтмал олборлолтын салбар эзэлж байна.

Ойлголт, тодорхойлолт:

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн: Аж ахуйн нэгж, байгууллагын тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нь тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг харуулна.

Тайлбар: ААНБ-ын мэдээнд суурилсан гүйцэтгэл

Эх үүсвэр: Статистикийн хэлтэс, Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, борлуулалтын сарын мэдээ

Ангилал, код: Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал; Бүтээгдэхүүн үйлчилгээний нэгдсэн ангилал;

ТЭЭВЭР, жил бүрийн эхний 9 сард

Авто тээвэр

	2022 I-IX	2023 I-IX
Зорчигчид, мянган хүн	11.0	11.1
Тээсэн ачаа, мянган тонн	148.0	174.0
Тээврийн орлого, тэрбум төгрөг	8.0	9.7

*Урьдчилсан гүйцэтгэл

Авто тээврийн орлого өмнөх оны мөн үеэс 20.2 хувиар өссөн байна.

Авто тээвэр бүхий байгууллагууд 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 174.0 мян.тн ачаа тээвэрлэж өмнөх оны мөн үеэс 26.0 (17.6%) мян.тн-оор өсжээ.

Бүтээгдэхүүн тээвэрлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл: нүүрс тээвэр 0.2 (1.0%) мянган тонноор, хүдэр тээвэр 63.3 мянган тонноор тус тус өссөн бол цайрын баяжмал 12.4 (13.0%) мянган тонноор буурчээ.

Мөн давхардсан тоогоор 11.1 мянган зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигчдын тоо 0.1 (0.5%) мянган хүнээр өсчээ.

Авто тээврийн орлого 9.6 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.6 (20.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ХҮСНЭГТ 9. ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ , жил бүрийн эхний 9 сард

Үзүүлэлт		Хэмжих нэгж	2022 I-IX	2023 I-IX	хувь
Тээсэн ачаа		мян.тн	148.0	174.0	117.6
Үүнээс	цайрын баяжмал	мян.тн	95.0	82.6	87.0
	нүүрс	мян.тн	21.0	21.2	101.0
	хүдэр	мян.тн	-	63.3	-
	Барилгын материал	мян.тн	-	5.9	-
	бусад	мян.тн	32.1	1.0	3.1
Ачаа эргэлт		мян.тн.км	35 331.0	48 218.0	136.5
Зорчигч		мян.хүн	11.0	11.1	100.5
Зорчигч эргэлт		мян.хүн.км	6 144.0	6 226.2	101.3
Тээврийн орлого		сая төг	8 035.0	9 660.4	120.2

Ойлголт тодорхойлолт:

Ачаа эргэлт: Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

Зорчигч эргэлт: Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

Шилжүүлсэн тонн километр: Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрд харилцан адилгүй тооцогддог.

Тээврийн орлого: Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.

СҮХБААТАР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ЭРДЭНЭБАТ

ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

III.а.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар

III.а.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар

III.б НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

IV. БОЛОВСРОЛ

IV.1 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ТӨГСӨГЧИД

IV.2 ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШИЖ ТӨГСӨГЧИД

V ЭРҮҮЛ МЭНД

V.1 ЭРҮҮЛ МЭНД

V.2 ТӨРӨЛТ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар

V.3 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧДИЙН ТОО, сумаар

VI СОЁЛ, УРЛАГ

VI.1 МЭРГЭЖЛИЙН УРЛАГЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТ

VI.2 МУЗЕЙН ҮЗҮҮЛЭЛТ

VI.3 НОМЫН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

VII ГЭМТ ХЭРЭГ

VII.1 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО

VII.2 БҮРТГЭГДСЭН ХЭРГИЙН ТОО, сумаар

VII.3 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО

VII.4 СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙН ТОО, сумаар

VIII МӨНГӨ, БАНК

VIII.1 ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖИЙН ҮЛДЭГДЭЛ, банкуудаар, сарын эцэст

IX АРИЛЖААНЫ ДААТГАЛ

IX.1 ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

X ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

X.1 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

X.2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

X.3 АЙМГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, сумаар

X.4 АЙМГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА, сумаар

XI ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨР

XI.1 ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР, сумаар

XII ҮНЭ

XII.а.1 ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

XII.а.2 ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ, хүнсний гол нэр төрлийн барааны дундаж үнэ

XII.б МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, сумаар, жил бүрийн 9 сарын байдлаар

XIII ХӨДӨӨ АЖ АХУЙ

XIII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, малын төрлөөр

XIII.2 МАЛ ТӨЛЛӨЛТ, сумаар

XIII.3 ТӨЛ БОЙЖИЛТ, малын төрлөөр

XIII.4 ТӨЛ БОЙЖИЛТ, сумаар

XIII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр

XIII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумаар

XIII.7 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, малын төрлөөр

XIII.8 ӨВЧНӨӨР ХОРОГДСОН МАЛ, сумаар

XIV АЖ ҮЙЛДВЭР

XIV.1 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

XIV.2 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, дэд салбараар

XIV.3 АЖ ҮЙЛДВЭРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

XIV.4 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, дэд салбараар

XIV.5 АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ГОЛ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ, нэр төрлөөр

II. ХӨДӨЛМӨР

II.1 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2021		2022		2023	2023 IX / 2022 IX
	IX	XII	IX	XII	IX	
	тоо					хувь
Нийт дүн	**496**	**563**	**352**	**363**	**71**	**20.2**
Асгат	8	8	3	2	2	66.7
Баяндэлгэр	30	51	7	4	-	-
Дарьганга	15	34	5	3	-	-
Мөнххаан	8	38	7	36	-	-
Наран	11	6	8	10	1	12.5
Онгон	15	37	11	8	4	36.4
Сүхбаатар	48	48	37	19	10	27.0
Түвшинширээ	46	83	69	72	4	5.8
Түмэнцогт	19	30	2	11	4	2.0 [1]
Уулбаян	38	10	12	10	-	-
Халзан	4	15	-	1	-	-
Эрдэнэцагаан	32	32	5	12	3	60.0
Баруун-Урт	222	171	186	175	43	23.1

II.2 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, боловсрол, насны бүлгээр

Сум	Бүгд	эмэгтэй	Боловсролын түвшингээр								Насны бүлгээр					
			Магистр, доктор	Дээд боловсролтой	Тусгай дунд боловсролтой	Мэргэжлийн анхан шатны	Бүрэн дунд боловсролтой	Суурь	Бага	Боловсролгүй	15-24	25-34	35-44	45-54	55-59	60+
Нийт дүн	**71**	**41**	**-**	**18**	**-**	**4**	**21**	**21**	**7**	**-**	**14**	**25**	**21**	**7**	**2**	**2**
Асгат	2	1	-	2	-	-	-	-	-	-	1	-	1	-	-	-
Баяндэлгэр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Дарьганга	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Мөнххаан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Наран	1	-	-	-	-	-	-	1	-	-	1	-	-	-	-	-
Онгон	4	2	-	-	-	-	2	1	1	-	-	-	1	2	-	1
Сүхбаатар	10	6	-	1	-	-	-	7	2	-	3	5	-	-	1	1
Түвшинширээ	4	3	-	1	-	-	-	1	2	-	1	2	1	-	-	-
Түмэнцогт	4	2	-	2	-	1	1	-	-	-	-	2	-	1	1	-
Уулбаян	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Халзан	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	3	2	-	2	-	-	-	1	-	-	-	3	-	-	-	-
Баруун-Урт	43	25	-	10	-	3	18	10	2	-	8	13	18	4	-	-

II.3 ШИНЭЭР БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭД, сумаар

Сум	2021		2022		2023	2023.I-IX / 2022.I-IX
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
	тоо					хувь
Нийт дүн	**1 642**	**2 589**	**1 606**	**2 390**	**1 204**	**75.0**
Асгат	75	95	63	126	56	88.9
Баяндэлгэр	100	193	20	30	4	20.0
Дарьганга	107	177	107	136	75	70.1
Мөнххаан	22	96	60	103	4	6.7
Наран	70	98	71	137	70	98.6
Онгон	59	141	20	41	82	4.1 [1]
Сүхбаатар	68	122	81	161	65	80.2
Түвшинширээ	126	258	250	355	178	71.2
Түмэнцогт	63	125	51	64	23	45.1
Уулбаян	94	124	46	82	39	84.8
Халзан	17	39	11	33	21	190.9
Эрдэнэцагаан	68	103	77	95	90	116.9
Баруун-Урт	773	1 018	749	1 027	497	66.4

II.4 БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭДЭЭС АЖИЛД ОРСОН ХҮН, сумаар

Сум	2021		2022		2023	2023 I-IX / 2022 I-IX
	I-IX	I-XII	I-IX	I-XII	I-IX	
	тоо					хувь
Нийт дүн	**329**	**607**	**313**	**761**	**380**	**121.4**
Асгат	46	52	43	104	50	116.3
Баяндэлгэр	5	35	2	6	1	50.0
Дарьганга	15	30	29	55	55	189.7
Мөнххаан	5	29	19	29	1	5.3
Наран	40	52	38	91	32	84.2
Онгон	8	49	-	17	45	-
Сүхбаатар	20	21	1	56	1	100.0
Түвшинширээ	37	81	66	153	45	68.2
Түмэнцогт	12	43	19	21	13	68.4
Уулбаян	20	37	18	38	21	116.7
Халзан	3	10	5	24	21	4.2 [1]
Эрдэнэцагаан	4	7	4	11	66	16.5 [1]
Баруун-Урт	114	161	69	156	29	42.0

II.5 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД АЖИЛЛАЖ БАЙГАА ХҮНИЙ ТОО, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Сум	Шинэ ажлын байранд орсон хүний тоо					Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар												
	2-22 I-IX	2-23 I-IX				Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	Уул уурхай, олборлолт	Боловсруулах аж үйлдвэр	Барилга	Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	Байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	Мэдээлэл, холбоо	Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	Боловсрол	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	Бусад
		Бүгд	Үүнээс															
			Байн-гын	Түр	Улирал													
Нийт дүн	**430**	**796**	**504**	**270**	**22**	**102**	**114**	**17**	**7**	**23**	**8**	**15**	**27**	**450**	**15**	**9**	**5**	**4**
Асгат	36	61	28	33	-	14	-	-	-	-	3	-	8	36	-	-	-	-
Баяндэлгэр	15	6	-	6	-	-	-	-	-	-	-	-	-	6	-	-	-	-
Дарьганга	15	123	80	43	-	11	-	1	-	-	-	-	7	86	8	7	3	-
Мөнххаан	37	44	22	17	5	-	-	-	-	4	-	-	-	40	-	-	-	-
Наран	21	77	31	39	7	2	-	1	-	1	-	-	-	72	1	-	-	-
Онгон	14	15	11	4	-	-	-	1	-	6	-	-	-	6	2	-	-	-
Сүхбаатар	43	13	13	-	-	5	-	3	-	1	-	-	1	-	1	-	2	-
Түвшинширээ	18	87	49	33	5	13	-	6	-	-	2	-	8	56	-	-	-	2
Түмэнцогт	17	27	27	-	-	-	-	-	-	-	-	-	-	27	-	-	-	-
Уулбаян	22	34	13	21	-	28	-	-	-	-	-	-	-	-	2	2	-	2
Халзан	19	15	11	2	2	-	-	-	-	-	-	15	-	-	-	-	-	-
Эрдэнэцагаан	19	180	131	46	3	6	114	5	7	2	-	-	-	46	-	-	-	-
Баруун-Урт	154	114	88	26	-	23	-	-	-	9	3	-	3	75	1	-	-	-

III. НИЙГМИЙН ДААТГАЛ, НИЙГМИЙН ХАЛАМЖ

III.а.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ, сумаар

Сум	Нийгмийн даатгалын шимтгэл				Сайн дурын даатгалын шимтгэлийн орлого			
	2022 I-IX	2023 I-IX			2022 I-IX	2023 I-IX		
		Төл	Гүйц	Гүйц / Төл		Төл	Гүйц	Гүйц / Төл
	сая төгрөг			хувь	сая төгрөг			хувь
Нийт дүн	**13 749.6**	**20 438.0**	**19 550.8**	**95.7**	**1 277.4**	**2 061.8**	**1 436.9**	**69.7**
Асгат	216.9	368.8	342.5	100.9	45.1	69.9	61.3	102.1
Баяндэлгэр	477.8	892.5	733.3	87.1	132.8	263.6	143.3	59.0
Дарьганга	346.4	578.2	544.3	101.0	69.1	105.7	82.8	84.4
Мөнххаан	411.0	719.1	630.6	86.0	96.2	151.9	115.7	78.8
Наран	199.7	364.0	319.9	92.5	59.8	90.1	52.5	64.7
Онгон	527.3	801.0	759.4	99.7	77.1	117.7	68.9	60.8
Сүхбаатар	311.4	637.9	571.2	94.5	84.5	128.1	85.2	71.5
Түвшинширээ	323.1	555.9	510.7	79.5	72.6	112.4	81.5	68.9
Түмэнцогт	466.7	803.6	632.4	81.3	47.3	71.9	52.3	74.0
Уулбаян	432.0	711.3	551.1	101.8	53.4	81.2	53.2	79.1
Халзан	216.8	347.5	315.1	100.1	34.0	54.2	33.7	71.6
Эрдэнэцагаан	807.5	1 440.2	1 447.4	107.2	194.8	319.0	213.7	72.5
Баруун-Урт	9 013.0	12 218.0	12 192.9	106.8	310.7	496.1	392.8	82.7

III.а.2 ТЭТГЭВЭР ОЛГОЛТ, сумаар

Сум	Тэтгэвэр авагчид				Олгосон тэтгэвэр			
	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX	2023 I-IX / 2022 I-IX	2021 I-IX	2022 I-IX	2023 I-IX	2023 I-IX / 2022 I-IX
	хүний тоо			хувь	сая төгрөг			хувь
Нийт дүн	**9 089**	**9 520**	**9 713**	**105.9**	**30 720.2**	**41 719.4**	**48 921.7**	**117.3**
Асгат	307	323	330	105.9	1 002.7	1 391.5	1 569.6	108.3
Баяндэлгэр	726	736	745	107.6	2 375.8	3 205.2	3 641.5	109.8
Дарьганга	460	485	493	106.6	1 479.3	2 035.7	2 260.2	107.5
Мөнххаан	576	612	621	99.2	1 866.3	2 587.3	2 850.0	106.4
Наран	245	267	273	113.7	833.8	1 191.1	1 363.2	110.2
Онгон	543	581	591	97.1	1 989.8	2 608.9	3 019.5	109.5
Сүхбаатар	421	470	479	117.9	1 391.8	1 969.0	2 222.1	90.1
Түвшинширээ	420	425	431	105.4	1 303.1	1 800.8	1 988.7	107.0
Түмэнцогт	391	409	420	107.9	1 315.4	1 801.5	2 025.5	107.8
Уулбаян	448	462	471	107.7	1 467.4	2 033.3	2 241.6	106.9
Халзан	238	257	267	112.2	793.7	1 128.6	1 260.5	107.8
Эрдэнэцагаан	959	925	943	90.7	3 053.9	4 168.1	6 127.7	107.7
Баруун-Урт	3 355	3 568	3 649	98.9	11 847.2	15 798.4	18 351.6	109.4

III.6 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2022 I-IX		2023 I-IX	
	Хүн тоо	сая.төг	Хүн тоо	сая.төг
Бүгд	**25 631**	**8 404.3**	**25 040**	**9 573.6**
Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, үйлчилгээ	**6 824**	**5 140.7**	**5 000**	**6 036.3**
